# 0.4кВ-ИЙН ГАДНА ЗОРИУЛАЛТЫН ЦАХИЛГААН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

# 2021



БАГАНУУР ЦАХИЛГААН МЕХАНИКИЙН ҮЙЛДВЭР

# ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭН МОНГОЛДОО ҮЙЛДВЭРЛЭЖ ХАМГИЙН ХЯМДААР ДОТООДДОО НИЙЛҮҮЛНЭ.

БОДИТ ҮНЭ

ӨНДӨР ЧАНАР


**4-7** ХУУДАС

- Компанийн тухай
- Үйлдвэрлэлийн баталгаа
- Дотоодын үйлдвэрийн давуу тал
- Зориулалт ба хамрах хүрээ

**8-27** ХУУДАС

ProCube.T

**Шон дээр суух зориулалттай 220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар**

- Ерөнхий танилцуулга
- Тоноглолын давуу тал
- Самбарын давуу тал
- 3 тоолууртай самбар
- 6 тоолууртай самбар
- Захиалгын хуудас
- Үйлдвэрлэх боломжит төрөл
- Худалдан авалт хийх шалтгаан

**28-29** ХУУДАС

- Иж бүрэн үйлчилгээ
- Холбоо барих



## КОМПАНИЙН ТУХАЙ

"БНЦМҮ" ХХК нь эрчим хүчний тоног төхөөрөмж үйлдвэрлэлийн салбарт арван жилийн туршлагатай үйлдвэр бөгөөд цахилгаан хангамжийн болон төмөр хийцлэлийн 300 гаруй нэр төрлийн тоног төхөөрөмжийг захиалагчийн хэрэгцээ шаардлага, цахилгаан техникийн дүрэм, олон улсын стандартад нийцүүлэн үйлдвэрлэдэг.

Манай шуурхай үйлчилгээний мэргэшсэн баг, хамт олон харилцагч нартаа иж бүрэн үйлчилгээ үзүүлж эргэх холбоотой хамтран ажилладаг тэдийгүй бидний үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүн захиалагч бүрийн үнэ цэнэтэй ул хөдлөх хөрөнгийг эрсдэлээс найдвартай хамгаалахаар зохион бүтээгддэг.

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАТАЛГАА

Бид бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлагыг чанарын хяналтаар баталгаажуулан өндөр хүчдэлийн туршилтын лабораторид туршиж үйлдвэрт ашиглалтад оруулдаг.

Гадна зориулалтын 0.4кВ-ын хуваарилах самбарыг IP43-54 хамгаалалтын зэрэглэлийг хангаж үйлдвэрлэж, байгаль цаг уурын бүхий л нөхцөлүүдийг тэсвэрлэх чадварыг шингээж өгдөг.

Хэрэглэгч захиалагчийн цахилгаан эрчим хүч тогтмол хэвийн ажиллагаатай байх нь манай үйлдвэрийн үнэт зүйл учраас бидний бүх үйлдвэрлэл таны цахилгааны найдвартай, аюулгүй ажиллагаагаар хангахад зориулагдсан.

## ДОТООДЫН ҮЙЛДВЭРИЙН ДАВУУ ТАЛ

Цахилгаан тоног төхөөрөмжийг захиалагчийн хүссэн техникийн шийдлээр зохион бүтээж цахилгаан техникийн дүрэмд нийцүүлэн олон улсын стандарт шаардлага хангасан түүхий эд материалаар тоноглож үйлдвэрлэдэг.

Сүүлийн жилүүдэд цахилгаан угсралтын компаниуд цахилгааны самбаруудаа өөрсдөө угсардаг уламжлалт хуучин хандлагаа халж, мэргэжлийн түвшинд үйлдвэрлэгч бидэнд даатгаснаар барилгын захиалагч болон гүйцэтгэгч компаниуд алтан цаг хугацаагаа хэмнэхийн зэрэгцээ ажлын бүтээмжээ нэмэгдүүлж байна.

Хуваарилах самбарын насан туршын ажиллагааг чухалчилж импортын бүтээгдэхүүнээс татгалзаж эхэлсэн энэ цаг үед үйлдвэрлэгч нар иж бүрэн үйлчилгээ үзүүлэн харилцагч нарын эрсдэлийг үүрч хамтран ажиллаж байна.

Бууж өгөх эзэн Буцах хаягтай үндэсний үйлдвэрлэгч компани танай хамт олонд Гадна зориулалтын цахилгаан тоног төхөөрөмжүүдийг санал болгож байна.



## ЦАХИЛГААНЫ УГСРАЛТ ХИЙХЭД ЗАЙЛШГҮЙ АНХААРАХ ДАРААХ ШААРДЛАГУУДЫГ БИД ШИЙДВЭРЛЭДЭГ

- Цахилгаан эрчим хүч хуваарилах самбар нь бүхэлдээ аюулгүй байдлыг бүрэн хангасан байх
- Дотор тоноглолууд нь чанартай бөгөөд найдвартай байх
- Хуваарилах самбарын ашиглалтын хугацаа урт байх
- Туршилтаар баталгаажиж үйлдвэрт ашиглалтад оруулсан байх
- Хэлбэр, хэмжээ, өнгө нь орчиндоо зохицсон байх
- Галын үнэлгээтэй байх
- Хэрэглэгчийн хэрэгцээ болон сэтгэлд нийцсэн байх

## ХЭРЭГЛЭЭ

- Гэр хороолол
- Амины орон сууц
- Зуслан хороолол
- Жуулчны бааз
- Амралт, сувилалын газар
- Шатахуун түгээх станц
- Хөдөө аж ахуй, ферм

# ProCube.T

**Шон дээр суух зориулалттай 220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар**

3-6 айлыг цахилгаанаар тэжээх, шон дээр суух зориулалттай
220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар



WE BUILD YOUR SAFETY
**WE BUILD YOUR SAFETY**
WE BUILD YOUR SAFETY

ProCube.T-3 | ProCube.T-6



## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НАЙДВАРТАЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСАН ШИЙДЭЛ:

- АЯНГЫН БОЛОН ДОТООД ХЭТ ХҮЧДЭЛИЙГ ШУУД ГАЗАРДУУЛАН ТРАНСФОРМАТОР, КАБЕЛЬ УТСЫГ ХАМГААЛДАГ
- АЧААЛАЛТАЙ ҮЕД ТАСЛАЛТ, ЗАЛГАЛТ ХИЙХ БОЛОМЖТОЙ
- БОГИНО ЗАЛГААНЫ ГҮЙДЭЛД ӨӨРИЙН БОЛОН ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ХЭРЭГСЛИЙГ ХАМГААЛДАГ
- ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛСАН.

## СТАНДАРТ

Шон дээр суух зориулалттай 220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар нь MNS 5643:2006, MNS 5644:2006 стандартын тохирлын гэрчилгээгээр баталгаажсан. Цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03, УБЦТС ТӨХК-ийн техникийн шаардлагууд болон IP-54 хамгаалалтын зэрэглэлийг бүрэн хангасан чанартай бүтээгдэхүүн юм.

BEMP

ProCube.T

Шон дээр суух зориулалттай 220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар





ProCube.T-3

ProCube.T загвар нь 3-6 айлыг 220В-оор тэжээх зориулалттай гадна цахилгааны шон дээр суурилдаг 0.4кВ-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар юм.

Энэхүү самбарыг Schneider electric компанийн Декрафт брэндийн тоноглолоор тоноглож аюулгүй ажиллагааг хангаж өгсөн. Оруулга хэсэгт автомат болон ачаалал таслагч, гаргалга хэсэгт энгийн болон дифференциал автомат суурилуулдаг. Хэрэглэгчийн хүсэлтээр 4 төрлөөр тоноглож монтажлах боломжтой.

Цахилгаан байгууламжийн дүрэм, техникийн шаардлагуудыг бүрэн хангаж, өнгө загвар болон хэрэглээний шинэлэг шийдлийг тусгасан.

Гадна самбарыг 1,5-2мм зузаантай цайртай лист төмөр материалаар хийж, гал дэмждэггүй ус чийгнээс хамгаалсан халцардаггүй хуурай будгаар будсан. Самбарын хаалга болон хаалтны битүүмжлэгч резинийг зориулалтын автомат машинаар шахаж IP43-54 хамгаалалтын зэрэглэлийг хангасан болно.

Гадаа шон дээр байрлах зориулалттай тул хүний санаатай болон санамсаргүй алдаанаас үүсэх эрсдэлийг бүрэн тооцсон төдийгүй урсгал засвар болон үзлэг хийхэд зориулан дотоод зохион байгуулалтыг сайтар төлөвлөж аюулгүй байдал, найдвартай ажиллагааг бүрэн хангасан.



ProCube.T-6




### Ерөнхий автомат

Богино залгаа үүссэн тохиолдолд 10.000А хүртэл хүчдэлийг тэсвэрлэн өнгөрөөх чадвартай бөгөөд цахилгаан дамжуулах утас нь 35 мм2 хүртэлх хөндлөн огтлолтой клеммууд өндөр гүйдлийн 125А хүртэл ачаалалтай цахилгаан хэлхээг хамгаалж чаддаг.

### Гаргалгын автомат

Гүйдэл дамжуулах хэсэгт санамсаргүй хүрэхээс хамгаалагдсан. Хүчдэлийн номиналь буюу өгөгдсөн гүйдлийн хэмжээ хязгаараас дээш болох эсвэл хязгаараас доош болж багассан тохиолдолд автоматаар унтраах зориулалттай.







### Ачаалал таслагч

Цахилгаан сүлжээнд хэт ачаалал болон богино залгаа үүсэх, хүчдэлд нэрвэгдэх, цахилгааны утсыг шатах зэрэг аюулаас хамгаалдаг.

### Кабель

Хайрцаг доторх кабелийн утас нь ГОСТ стандартын шаардлагыг хангасан галын А үнэлгээтэй бөгөөд гал дэмжлэггүй материалтай кабель далдлагчаар монтажны эмх цэгцийг хангасан. Ингэснээр тоолуур болон автоматуудаа бүрэн хамгаалдаг онцлогтой.







### Самбарын их бие

Тоолуурын хуваарилах самбарын дээвэр, хаалга, модулийн хаалт болон их биеийг цахилгаан техникийн дүрэмд нийцсэн 1,5-2мм зузаантай цайртай лист төмрөөр хийж, гал дэмждэггүй хуурай будгаар буддаг.

### Модулийн хаалт

Модулийн хаалт нь хаалга нээлттэй байх нөхцөлд хүчдэлд өртөх магадлалтай бүх хэсгийг далдалж өгсөн бөгөөд тоолуурын хаалтаа харах боломжтой нэмэлт цонх гаргаж өгсөн ухаалаг, хялбар шийдэлтэй.





### Гаралтын автоматны хэсэг

Хэрэглэгчийн харьцах гаралтын автоматны таслаж залгах буюу хүний гар хүрч болох хэсгийг ил байхаар шийдэж өгсөн. Энэ нь шугам сүлжээний ажилтнуудын оролцоогүйгээр шаардлагатай нөхцөлд аюулгүй байдлаар таслаж залгах боломжийг бүрдүүлсэн.

### Бүслүүрийн хэсэг

Хуваарилах самбарыг шон дээр суурилуулахад зориулан их биеийн арын хэсэгт бүслүүр бэхлэх зориулалтын нүх гаргаж өгсөн.





### Хаалга, хаалганы тээглүүр

Урсгал засвар үйлчилгээ хийх зориулалтаар доторх зай талбайг нарийн төлөвлөж хаалгыг 110* онгойх байдлаар зохион бүтээсэн. Мөн хаалганы доод хэсэгт тээглүүр хийж өгснөөр үзлэг хийх явцад хаалга савах эрсдэлийг зогсоосон.

### IP54

Самбарын дээвэр хэсэг борооны хаалттай бөгөөд битүүмжлэлийг хангах хаалганы резинийг тусгай зориулалтын машинаар шахаж IP54 хамгаалалтын зэрэглэлийг хангасан.





### 4 чигийн цоож

Самбарын аюулгүй байдал, бат бөх чанарыг хадгалах зорилгоор 4 чигийн цоожны шийдлийг гаргасан. Цоожлох үед 4 чигт дэгээгээр тээглэгдэг тул гадны нөлөөлөлд өртөх, хөшиж онгойлгох зэрэг эрсдэлийг хязгаарлаж өгсөн.

## ProCube.T 3 тоолууртай самбар

ProCube.T-3 загвар нь 3 ширхэг тоолуур суурилуулан 3 айлыг цахилгаанаар тэжээн шон дээр байрладаг гадна зориулалтын 220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар юм. Гэр хороолол болон зуслан, амины орон сууц, амралт сувилалын газар, жуулчны бааз, хөдөө аж ахуй зэрэг алслагдсан байршилтай байгууламжийг цахилгаан тэжээлээр хангах дамжуулах үүрэгтэй.
Захиалагчийн хүсэлтээр дараах 4 төрлөөр монтажилж нийлүүлдэг.

- Гаргалгын энгийн автомат таслуур
- Гаргалгын дифференциал автомат таслуур
- Ачаалал таслагч
- Ачаалал таслагч болон гаргалгын дифференциал автомат таслуур

220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар нь хэрэглэгч болон шугам сүлжээний ажилтан нарын хяналтыг хялбаршуулсан хийцтэй бөгөөд IP54 хамгаалалтын зэрэглэлтэй бүтээгдэхүүн юм.
Гаргалгын автомат таслуурын тасалж залгах болон тоолуурын заалтны хэсгийг ил гаргаж өгсөнөөр автомат таслууртай аюулгүй харьцах, гадны сөрөг хүчин зүйлээс сэргийлэх боломжтой болсон. Мөн хэрэглэгч тоолуурын заалт буюу хэрэглээгээ чөлөөтэй хянах боломжийг давхар бүрдүүлж өгсөн.





ProCube.T

## Техникийн үзүүлэлт

| | |
|---|---|
| **Еренхий** | |
| Бүтээгдэхүүний төрөл | Гадна зориулттай тоолуурын самбар |
| Бүрэлдэхүүн хэсгийн төрөл | ProCube |
| Бүтээгдэхүүний богино нэр | PC.T-3 |
| Бүтээгдэхүүний ашиглах хүрээ | Орон сууц |
| Оруулгын төрөл | Кабелийн оруулгатай |
| Гаргалгын төрөл | Кабелийн гаргалгатай |
| Ашиглах зориулалт | Суурин |
| Хамгаалалтын зэрэглэл | IP54 |
| **Үзүүлэлт** | |
| Сүлжээний фазын тоо | 3 фаз |
| Давтамж | 50hz |
| U хэвийн хүчдэл | 400/230В |
| Нам хүчдэлийн хэвийн А | 16-125А |
| Гаргалга | - 4.5 кА энгийн автомат<br>- 30-100мА дифференциал автомат<br>- Ачаалал таслагч, 4.5кА энгийн автомат<br>- Ачаалал таслагч, 30-100mA дифференциал автомат |
| Тоолуур | 1-3 тоолуур суух боломжтой |
| Icu богино залгааны таслах гүйдлийн хязгаар | 4.5-10кА |
| Зузаан | 190мм |
| Өргөн | 320мм |
| Өндөр | 1275мм |
| **Нэмэлт** | |
| Стандарт | ISO9001:2015, MNS 5834:2008 |
| Ашиглалтын орчны агаарын температур | -50*C...+50*C |
| Хадгалах орчны агаарын температур | -40*C...+50*C |

## Хэмжээст зураг






## Схем зураг




ProCube.T3

- Ерөнхий автомат
- Тоолуур
- Гаралтын энгийн автомат




ProCube.T3-M

- Ерөнхий автомат
- Тоолуур
- Гаралтын дифференциал автомат




ProCube.T3-R

- Ерөнхий автомат
- ачаалал таслагч
- Тоолуур
- Гаралтын энгийн автомат




ProCube.T3-MR

- Ерөнхий автомат
- ачаалал таслагч
- Тоолуур
- Гаралтын дифференциал автомат

## ProCube.T 6 тоолууртай самбар

ProCube.T-6 загвар нь 6 ширхэг тоолуур суурилуулан 6 айлыг цахилгаанаар тэжээн шон дээр байрладаг гадна зориулалтын 220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар юм. Гэр хороолол болон зуслан, амины орон сууц, амралт сувилалын газар, жуулчны бааз, хөдөө аж ахуй зэрэг алслагдсан байршилтай байгууламжийг цахилгаан тэжээлээр хангах дамжуулах үүрэгтэй.
Захиалагчийн хүсэлтээр дараах 4 төрлөөр монтажилж нийлүүлдэг.

- Гаргалгын энгийн автомат таслуур
- Гаргалгын дифференциал автомат таслуур
- Ачаалал таслагч
- Ачаалал таслагч болон гаргалгын дифференциал автомат таслуур

220В-ын тоолуурын нэгдсэн удирдлагын самбар нь хэрэглэгч болон шугам сүлжээний ажилтан нарын хяналтыг хялбаршуулсан хийцтэй бөгөөд IP54 хамгаалалтын зэрэглэлтэй бүтээгдэхүүн юм. Гаргалгын автомат таслуурын тасалж залгах болон тоолуурын заалтны хэсгийг ил гаргаж өгсөнөөр автомат таслууртай аюулгүй харьцах, гадны сөрөг хүчин зүйлээс сэргийлэх боломжтой болсон. Мөн хэрэглэгч тоолуурын заалт буюу хэрэглээгээ чөлөөтэй хянах боломжийг давхар бүрдүүлж өгсөн.





ProCube.T

## Техникийн үзүүлэлт

| | |
|---|---|
| **Ерөнхий** | |
| Бүтээгдэхүүний төрөл | Гадна зориулттай тоолуурын самбар |
| Бүрэлдэхүүн хэсгийн төрөл | ProCube |
| Бүтээгдэхүүний богино нэр | PC.T-6 |
| Бүтээгдэхүүний ашиглах хүрээ | Орон сууц |
| Оруулгын төрөл | Кабелийн оруулгатай |
| Гаргалгын төрөл | Кабелийн гаргалгатай |
| Ашиглах зориулалт | Суурин |
| Хамгаалалтын зэрэглэл | IP54 |
| **Үзүүлэлт** | |
| Сүлжээний фазын тоо | 3 фаз |
| Давтамж | 50hz |
| U хэвийн хүчдэл | 400/230В |
| Нам хүчдэлийн хэвийн А | 16-125А |
| Гаргалга | - 4.5 кА энгийн автомат<br>- 30-100мА дифференциал автомат<br>- Ачаалал таслагч, 4.5кА энгийн автомат<br>- Ачаалал таслагч, 30-100mA дифференциал автомат |
| Тоолуур | 4-6 тоолуур суух боломжтой |
| Icu богино залгааны таслах гүйдлийн хязгаар | 4.5-10кА |
| Зузаан | 190мм |
| Өргөн | 540мм |
| Өндөр | 1275мм |
| **Нэмэлт** | |
| Стандарт | ISO9001:2015, MNS 5834:2008 |
| Ашиглалтын орчны агаарын температур | -50*C...+50*C |
| Хадгалах орчны агаарын температур | -40*C...+50*C |

## Хэмжээст зураг







ProCube.T

## Схем зураг




ProCube.T6

- Ерөнхий автомат
- Тоолуур
- Гаралтын энгийн автомат




ProCube.T6-M

- Ерөнхий автомат
- Тоолуур
- Гаралтын дифференциал автомат




ProCube.T6-R

- Ерөнхий автомат
- ачаалал таслагч
- Тоолуур
- Гаралтын энгийн автомат




ProCube.T6-MR

- Ерөнхий автомат
- ачаалал таслагч
- Тоолуур
- Гаралтын дифференциал автомат

Үйлдвэрлэх боломжит төрлүүд

ProCube.T

Үйлдвэрлэх боломжит төрлүүд

IP43 хамгаалалтын зэрэг хангасан



IP54 хамгаалалтын зэрэг хангасан



**ВЕМР** | ISO 9001

## ШОН ДЭЭР СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ 220В-ЫН ТООЛУУРЫН НЭГДСЭН УДИРДЛАГЫН САМБАР ЗАХИАЛГЫН ХУУДАС

**БАЙГУУЛЛАГЫН НЭР:** ........................................

**РЕГИСТРИЙН ДУГААР:** ........................................

**БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ:** ........................................

........................................

**ТӨСЛИЙН НЭР:** ........................................

**ЗАХИАЛАХ ТОО ШИРХЭГ:** ........................................

**УТАСНЫ ДУГААР:** ........................................

**ИМЭЙЛ ХАЯГ:** ........................................

**ЗАХИАЛГЫН ДУГААР:** ........................................

**ЗАХИАЛГА ӨГСӨН ОГНОО:** ................../............/..........

### ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

**ТООЛУУРЫН ТОО**

- ☐ 2 тоолуууртай
- ☐ 3-тоолуууртай
- ☐ 4-тоолуууртай
- ☐ 5 тоолуууртай
- ☐ 6 тоолуууртай
- ☐ .................... Тусгай захиалга бичих

### ТОНОГЛОЛ СОНГОХ ТӨРЛҮҮД

**ТООЛУУРЫН САМБАРЫН ТОНОГЛОХ ТӨРӨЛ**

- ☐ **ProCube.T-D** — Ерөнхий автомат, Тоолуур, Гаралтын энгийн автомат
- ☐ **ProCube.T-M-D** — Ерөнхий автомат, Тоолуур, Гаралтын дифференцал автомат
- ☐ **ProCube.T-R-D** — Ерөнхий автомат, Ачаалал таслагч, Тоолуур, Гаралтын энгийн автомат
- ☐ **ProCube.T-MR-D** — Ерөнхий автомат, Ачаалал таслагч, Тоолуур, Гаралтын дифференцал автомат

**ОРУУЛГЫН ГҮЙДЭЛ**

- ☐ 63A
- ☐ 80A
- ☐ 100A
- ☐ 125A

**ГАРГАЛГЫН ГҮЙДЭЛ**

- ☐ 16A
- ☐ 25A
- ☐ 32A
- ☐ 40A
- ☐ 50A
- ☐ 63A

### НЭМЭЛТ САНАЛ ХҮСЭЛТ

........................................................................................

........................................................................................

........................................................................................

**ХЭЛТЭС, АЛБА:** ........................................

**АЛБАН ТУШААЛ:** ........................................

**ОВОГ НЭР:** ........................................

**ГАРЫН ҮСЭГ:** ........................................



1. Буух эзэн буцах хаягтай дотоодын туршлагатай үйлдвэрлэгч
2. Дотоодын үйлдвэрлэл шуурхай нийлүүлэлт
3. Төлбөрийн уян хатан нөхцөл
4. Захиалагчийн хүссэн шийдлээр тоноглох сонголт
5. Өнгө болон хийц загварын өргөн сонголт
6. Насан туршын найдвартай ажиллагаа
7. Борлуулалтын дараах бүх төрлийн үйлчилгээ



## ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

БНЦМУ ХХК нь үйлчилгээний сүлжээг хөгжүүлж, дотооддоо бэлтгэгдсэн шуурхай үйлчилгээний баг бүрдүүлэн ажилладаг.
Шуурхай үйлчилгээний баг нь харилцагч нартаа борлуулалтын дараах бүх төрлийн үйлчилгээг үзүүлж таны хүлээлтийг давсан үйлчилгээг үзүүлэх болно.

## 0.4КВ-ЫН ГАДНА ЗОРИУЛАЛТТАЙ САМБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДАА

Захиалагч талаас Борлуулалтын менежерт цахилгааны ажлын зураг болон материалын түүвэр өгснөөр бүтээгдэхүүний үнийн санал болон уян хатан төлбөрийн нөхцөлийг ажлын 1-2 хоногт хүлээн авна.

Захиалагч талын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гадна зориулалтын 0.4кВ-ийн цахилгаан тоног төхөөрөмжийг үйлдвэрлэж, үйлдвэрлэлийн явцад тогтмол мэдээллээр хангана. Захиалж буй тоо ширхэгээс хамааран 5-14 хоногт нийлүүлж, суурилуулалтын ажлын зураг, зөвлөмж болон бүтээгдэхүүний дагалдах баримт бичгийг хүлээлгэн өгнө.

Бид өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээгээ бүрэн хариуцаж, таны найдвартай хамтрагч байх болно.

## ЭД АНГИ БОЛОН ТОНОГЛОЛЫН ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

Чадварлаг мэргэшсэн шуурхай баг баталгаат хугацааны турш тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг бүрэн хариуцахаас гадна, борлуулалтын дараах цогц үйлчилгээг үзүүлж байна.

- Угсралт суурилалтын зөвлөгөө
- Эвлэжит үзлэг оношлогоо, засвар үйлчилгээ
- Хүчин чадлаа нэмэгдүүлэх боломж
- Эд анги болон тоноглолын
- Худалдаа, үйлчилгээ
- Бусад үйлчилгээ

## БАТАЛГААТ ХУГАЦААНЫ ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭ, СЭЛБЭГИЙН ХУДАЛДАА

Цахилгаан тоног төхөөрөмж нь урт хугацааны туршид аюулгүй найдвартай ажиллагаатай байх нь бидний эрхэм үнэт зүйл юм.
Баталгаат хугацаа дууссаны дараа харилцагч нартай эргэх холбоотой хамтран ажиллаж, дараах үйлчилгээг санал болгодог.

- Олон улсын стандарт хангасан чанартай сэлбэгийг үйлдвэрийн үнээр нийлүүлнэ.
- Цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжид үзлэг оношлогоо хийнэ.
- Инженерийн баг мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.
- Засвар үйлчилгээ хийж эдэлгээний хугацааг уртасгана.

Бид таны насан туршийн харилцагч, хамтрагч компани байх болно.

Note:

Note:

**Үйлдвэрийн төв байр:** Монгол улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3 дугаар хороо, Уурхайчдын гудамж, Үйлдвэрийн хэсэг, Багануур цахилгаан механикийн үйлдвэр

**Showroom хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Сонсголонгийн гудамж, 20-р хороо, Дэвшил трейдын автобусны буудлын замын эсрэг талд буюу 013 дугаар Цэргийн ангийн хажуу талд Электрокомплект ХХК-ийн байр

7021-0210

9955-6757
9955-6707
9955-6747

sales@bemp.mn
info@bemp.mn

www.bemp.mn